



ХЭНТИЙ АЙМАГ  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 12 сарын 10 өдөр

Дугаар 6/62

Чингис хот

Шагнаж урамшуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Төрийн албаны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2, 31.3 дахь заалт, Засгийн газрын 1995 оны 96 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчид шагнал, урамшуулал олгох журам"-ын 5, 9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төрийн албан хаагчдын сахилга хариуцлагыг сайжруулах нь удирдах ажилтны 2 дугаар зөвлөгөөн, сургалтын арга хэмжээг зохион байгуулалтын өндөр хэмжээнд зохион байгуулсан тул дараах албан хаагчдыг 1 сарын албан тушаалын үндсэн цалингийн 10 хувьтай тэнцэх мөнгөн шагналаар шагнасугай.

Ж.Гантулга	-Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга
Ч.Болормаа	-Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн мэргэжилтэн
Д.Ганболд	-Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн мэргэжилтэн
С.Оюун-Эрдэнэ	-Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн мэргэжилтэн
Д.Зоригтбаясгалан	-Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн мэргэжилтэн
Ж.Энхбат	-Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн мэргэжилтэн
Ц.Ганчимэг	-Хяналт шинжилгээ үнэлгээ дотоод аудитын хэлтсийн мэргэжилтэн
Б.Мөнгөнцэцэг	-Архивын тасгийн дарга
Ж.Ганбаяр	-Хууль эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн

2. Шагналд зарцуулах хөрөнгийг байгууллагын төсвийн холбогдох зардлаас зарцуулахыг нягтлан бодогч /Э.Ариунтунгалаг/-д зөвшөөрсүгэй.

3. Шагнаж урамшуулсан тушаалын хуулбарыг албан хаагчдын хувийн хэрэгт хавсаргахыг Хүний нөөцийн удирдлага, агентлаг хариуцсан мэргэжилтэн Ч.Болормаад даалгасугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР